



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/15

Булган

2019 онд амжилт гаргасан тамирчинд
мөнгөн урамшуулал олгох тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад мөнгөн шагнал олгох журам”, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны Самбо бөхийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль хүртсэн Д.Пүрэвдоржид 1 000 000 /нэг сая/ төгрөгийн мөнгөн урамшуулал олгосугай.

2. Дээрхи хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.



З.БАТЗОРИГ

20200029